



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/236

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуш модны самар бэлтгэсэн аж ахуйн нэгжүүдийн хувийн хөрөнгөөр ойжуулсан талбайг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Очирхуяг (Ойн ангийн дарга)

Гишүүд: Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)

Ш.Бумандолгор (Ойн ангийн инженер)

А.Мягмардавга (Ойн ангийн инженер)

2.Талбайг 2025 оны 02 дугаар сарын 15-ны дотор хүлээн авч, танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Д.Очирхуяг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ

